

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2026/078/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2026 оны 01 дүгээр сарын 29</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Нарангэрэл</p> <p>Утас: 99009293 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

「**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭНХ-АМГАЛАН ТАНАА**

2026. 01. 27 № 2/01

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Худалдан авах ажиллагааны газрын санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд 306,645.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 300,992.0 мянган төгрөгийн санхүүжилт авч,

6426030002

гүйцэтгэлээр 291,043.1 мянган төгрөгийг зарцуулж, 9,948.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 90.0 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,710,440.00	6,868,410.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
3121	Төгрөг	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,710,440.00	6,868,410.00
354	Хангамжийн материал	4,710,440.00	6,868,410.00
35410	Бичиг хэргийн материал	561,260.00	815,230.00
35420	Аж ахуйн материал	3,909,180.00	4,993,180.00
35440	Түлш, шатах тослох материал	240,000.00	1,060,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,367,573.12	37,785,752.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	32,367,573.12	37,785,752.84
392	Биет хөрөнгө	31,652,573.09	37,290,752.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,699,600.00	61,275,290.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,061,052.68	-28,594,039.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,490,520.00	10,830,520.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,476,494.23	-6,221,017.60
393	Биет бус хөрөнгө	715,000.03	495,000.07
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-164,999.97	-384,999.93
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	37,078,013.12	44,654,162.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,078,013.12	44,654,162.84
51	Засгийн газрын хувь оролцоо	37,078,013.12	44,654,162.84
512	Хуримтлагдсан үр дүн	37,078,013.12	44,654,162.84
51210	Өмнөх үеийн үр дүн	37,078,013.12	37,078,013.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	7,576,149.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	37,078,013.12	44,654,162.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	358,957,542.39	323,287,333.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,588,488.89	15,913,333.36
120	Нийтлэг татварын бус орлого	21,588,488.89	15,913,333.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,050,105.00	5,355,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,050,105.00	5,355,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	337,369,053.50	307,374,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,232,453.50	11,737,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,232,453.50	11,737,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	310,136,600.00	295,637,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	310,136,600.00	295,637,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	321,879,529.27	315,676,683.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	321,879,529.27	315,676,683.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,652,249.42	289,941,797.46

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,157,804.00	225,627,511.00
210101	Үндсэн цалин	119,452,479.00	119,606,790.00
210102	Нэмэгдэл	84,569,108.00	86,142,721.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,466,000.00	11,145,000.00
210104	Урамшуулал	9,670,217.00	8,733,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,144,715.01	28,174,072.82
210201	Тэтгэврийн даатгал	19,138,406.06	19,158,369.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,577.24	2,253,925.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,125,788.62	1,126,962.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,125,788.62	1,126,962.92
210205	Эрүүл мэндийн даатгал	4,503,154.47	4,507,851.64
2104	Хангамж, бараа материалын зардал	8,821,570.64	10,038,439.00
210401	Бичиг хэрэг	3,377,340.00	3,428,030.00
210402	Тээвэр, шатахуун	3,510,000.00	3,760,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,445,730.64	2,399,409.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	348,200.00	25,000.00
210408	Бараа материал акалсны зардал	140,300.00	426,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	5,726,810.00
210604	Урсгал засвар	00.00	5,726,810.00
2107	Томилолт, зочны зардал	8,084,000.00	2,548,400.00
210702	Дотоод албан томилолт	8,084,000.00	2,548,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,196,749.00	3,510,221.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,196,749.00	2,449,221.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	561,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,247,410.77	14,316,343.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,071,500.00	350,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,175,910.77	13,966,343.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,227,279.85	25,734,886.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,732,453.50	15,786,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	4,049,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,232,453.50	11,737,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,494,826.35	9,948,886.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,494,826.35	9,948,886.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,078,013.12	7,610,649.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	34,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	34,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-34,500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	37,078,013.12	7,576,149.72

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	345,419,158.50	312,729,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,050,105.00	5,355,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,050,105.00	5,355,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,050,105.00	5,355,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,050,105.00	5,355,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	337,369,053.50	307,374,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,232,453.50	11,737,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,232,453.50	11,737,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	310,136,600.00	295,637,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	310,136,600.00	295,637,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	316,815,158.50	303,733,310.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	316,815,158.50	303,733,310.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,587,878.65	277,998,423.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,157,804.00	225,627,511.00
210101	Үндсэн цалин	119,452,479.00	119,606,790.00
210102	Нэмэгдэл	85,362,325.00	86,142,721.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,466,000.00	11,145,000.00
210104	Урамшуулал	8,877,000.00	8,733,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,144,715.01	28,174,072.82
210201	Тэтгэврийн даатгал	19,138,406.06	19,158,369.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,577.24	2,253,925.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,125,788.62	1,126,962.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,125,788.62	1,126,962.92
210205	Эрүүл мэндийн даатгал	4,503,154.47	4,507,851.64
2104	Хангамж, бараа материалын зардал	9,577,110.64	11,591,409.00
210401	Бичиг хэрэг	2,748,600.00	3,212,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,750,000.00	4,580,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,788,930.64	2,399,409.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,289,580.00	1,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,166,000.00	4,997,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	176,000.00	00.00
210604	Урсгал засвар	990,000.00	4,997,310.00
2107	Томилолт, зочны зардал	8,084,000.00	2,548,400.00
210702	Дотоод албан томилолт	8,084,000.00	2,548,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,636,749.00	4,709,721.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,196,749.00	2,449,221.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	1,760,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,821,500.00	350,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,821,500.00	350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,227,279.85	25,734,886.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,732,453.50	15,786,000.00

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	4,049,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,232,453.50	11,737,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,494,826.35	9,948,886.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,494,826.35	9,948,886.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,604,000.00	8,995,690.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,604,000.00	8,995,690.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,604,000.00	8,995,690.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,604,000.00	8,995,690.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,604,000.00	8,995,690.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28,604,000.00	-8,995,690.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	37,078,013.12	37,078,013.12
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	37,078,013.12	37,078,013.12
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	37,078,013.12	37,078,013.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	37,078,013.12	37,078,013.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	7,576,149.72	7,576,149.72
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	44,654,162.84	44,654,162.84

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Тайлангийн үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,645,700.00	300,992,000.00	5,653,700.00	98.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,645,700.00	300,992,000.00	5,653,700.00	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,596,700.00	286,994,113.82	15,602,586.18	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,275,700.00	225,627,511.00	9,648,189.00	95.9
210101	Үндсэн цалин	122,051,000.00	119,606,790.00	2,444,210.00	98.0
210102	Нэмэгдэл	92,255,900.00	86,488,244.00	5,767,656.00	93.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,360,000.00	11,145,000.00	215,000.00	98.1
210104	Урамшуулал	9,608,700.00	8,387,477.00	1,221,223.00	87.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,409,500.00	28,174,072.82	1,235,427.18	95.8
210201	Тэтгэврийн даатгал	19,998,400.00	19,158,369.54	840,030.46	95.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,352,800.00	2,253,925.80	98,874.20	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,176,400.00	1,126,962.92	49,437.08	95.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,176,400.00	1,126,962.92	49,437.08	95.8
210205	Эрүүл мэндийн даатгал	4,705,500.00	4,507,851.64	197,648.36	95.8
2104	Хангамж, бараа материалын зардал	12,439,500.00	11,591,409.00	848,091.00	93.2
210401	Бичиг хэрэг	3,400,000.00	3,212,000.00	188,000.00	94.5
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	4,580,000.00	420,000.00	91.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,539,500.00	2,399,409.00	140,091.00	94.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,400,000.00	100,000.00	93.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	13,993,000.00	7,000.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	8,995,690.00	4,310.00	100.0
210602	Тавилга	00.00	00.00	0.00	
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,997,310.00	2,690.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	2,548,400.00	2,451,600.00	51.0
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	2,548,400.00	2,451,600.00	51.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,411,500.00	4,709,721.00	701,779.00	87.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,151,000.00	2,449,221.00	701,779.00	77.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,760,500.00	1,760,500.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1060600.00	350000.00	710,600.00	33.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,060,600.00	350,000.00	710,600.00	33.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,049,000.00	4,049,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,049,000.00	4,049,000.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,049,000.00	4,049,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	0.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	306,645,700.00	300,992,000.00	5,653,700.00	98.2

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	299,645,700.00	295,637,000.00	4,008,700.00	98.7
132001	Орон нутгийн төсвөөс	299,645,700.00	295,637,000.00	4,008,700.00	98.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,000,000.00	5,355,000.00	1,645,000.00	76.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	5,355,000.00	1,645,000.00	76.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	8	7	1	87.5
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	5	4	1	80.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,737,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,737,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,737,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,737,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,737,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,737,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,737,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	өнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь “Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, төрийн худалдан авах ажиллагаанд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд оршино” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас тус байгууллагад хяналт, шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,576.1 мянган төгрөг буюу 20.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	1	2	3	4	5	6
А						
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,710.4	12.7%	6,868.4	15.4%	2,158.0	45.8%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Авлага	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	4,710.4	12.7%	6,868.4	15.4%	2,158.0	45.8%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	32,367.6	87.3%	37,785.8	84.6%	5,418.2	16.7%
Үндсэн хөрөнгө	51,070.1	137.7%	72,985.8	163.4%	21,915.7	42.9%
Хуримтлагдсан элэгдэл	(18,702.5)	-50.4%	(35,200.1)	-78.8%	(16,497.5)	88.2%
Нийт хөрөнгө	37,078.0	100.0%	44,654.2	100.0%	7,576.1	20.4%
Өр төлбөр	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	37,078.0	100.0%	44,654.2	100.0%	7,576.1	20.4%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	37,078.0	100.0%	44,654.2	100.0%	7,576.1	20.4%

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 6,868.4 мянган төгрөг болж 2,158.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 14,188.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 135.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 11,739.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 426.0 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж устгасан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 72,985.8 мянган төгрөг болж 21,915.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,995.7 мянга, аймгийн Иргэдийн

төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 7/40 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газраас 13,300.0 мянган төгрөгийн өртөг бүхий Махhub маркийн ухаалаг дэлгэцийг балансаас балансад шилжүүлэн авч, хамт олны хамтын сангийн хөрөнгөөр 670.0 мянган төгрөгийн өртөг бүхий төмөр сейфийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 7/42 дугаар тогтоолоор 1,050.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг актлах шийдвэр гарсны дагуу данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 44,654.2 мянган төгрөг болж 7,576.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 7,576.1 мянган төгрөгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 686,153.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 686,153.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 379,508.2 мянган төгрөгөөр бууруулж 306,645.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 345,020.2 мянган төгрөгийн төсөв баталсан ч 2025 оын 09 дүгээр сард төсвийг тодотгон баталж, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 295,637.0 мянга, өөрийн орлогоос 5,355.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 291,043.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 291,043.1 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь байр цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 9,648.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,235.4 мянга, хангамж бараа материалын зардал 848.1 мянга, томилолт зочны зардал 2,451.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 701.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 710.6 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					<i>/мянган төгрөгөөр/</i>
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглал	306,645,600.00	300,992,000.00	5,653,600.00	83.7%
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	302,596,600.00	296,943,000.00	5,653,600.00	81.6%
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,049,000.00	4,049,000.00	0.00	85.8%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын сургалт семинар зөвлөгөөнд зарцуулахаар 1060.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 350.0 мянган төгрөг, унаа хоолны хөнгөлөлтөд 11,360.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 11,145.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллага нь хоол, унааны зардлыг байгууллагын дарга тушаал гарган оны эхэнд 5.0 мянган төгрөгөөр тооцож олгож байсан ч цалингийн хэмнэлтээс шалтгаалан 9 дүгээр сард 15.0 мянга, 12 дугаар сард 20.0 мянган төгрөг болгон өсгөн олгосон байна.

Бүтэц орон тоог Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 1, гүйцэтгэх 7 албан тушаалтны орон тоог баталсан бөгөөд Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 8/45 дугаар “Баянхонгор аймгийн 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг үндэслэн бичиг хэргийн ажилтны орон тоог цомхотгосон байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 11,737.0 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан нэг албан хаагчид 5 жил тутамд олгодог мөнгөн урамшууллыг олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Бямбадорж зурж байсан бол Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Б/66 дугаар захирамжаар Н.Энх-Амгаланг түр орлон гүйцэтгэгчээр томилж, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 315,676.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,156.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 2,051.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 оны бичиг хэргийн зардлыг 188.0 мянга буюу 5.5%-иар хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 298,460.3 мянган төгрөгийн 13 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 25,812.2 мянган төгрөгийн 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 13,523.2 мянган төгрөгийн 13 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын удирдлагаас хоолны хөнгөлөлтийг 5.0-20.0 мянган төгрөг хүртэл харилцан ялгаатай байдлаар сар бүр өөрчлөн олгож байгаа нь нэгдсэн бодлого зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна. Иймээс Сангийн яамнаас хоолны хөнгөлөлтийг олгох нөхцөл, шалгуур, хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,855.0 мянган төгрөгийн нэг зөрчил¹ илэрсэнд цаашид давтан гаргахгүй байх дээрх зөрчлийг арилгах нэг албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 1,855.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,301.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тус байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь цалингийн зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас өөртөө шийдвэр гарган нийт 1,855.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид байгууллагын дарга нь өөртөө шийдвэр гаргадаг байдлыг таслан зогсоож, эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь цалингийн зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас өөртөө шийдвэр гарган нийт 1,855.0 мянган төгрөгийг зарцуулжээ.	1	1,855.0			1	1,855.0		
Нийт дүн	1	1,855.0			1	1,855.0		

-----oOo-----

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар
Тайлант хугацаа: 2025

мянган төгрөгөөр

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар
Тайлант хугацаа: 2025 он

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас	
								Албан тушаал	Овог нэр
1	Зардал	Тус байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө шийдвэр гаргаж 2025.11.10-ны өдрийн тушаалаар эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, мөн 2025.01.02-ны өдрийн Б/01, 2025.10.03-ны өдрийн Б/13, 2025.12.01-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар албан хаагчдад хоол унааны нэмэгдэл олгох шийдвэр гарган нийт 1455.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт эдэлсэн нь нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн	1,855.0	Албан шаардлага	байхгүй	Зөрчлийг арилгаж, эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулах	Зөрчлийг арилгаж, эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулах	Дарга, нягтлан бодогч	Н.Энх-Амгалан Д.Мөнхтуяа
			1,855.0						

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Б.НАРАНГЭРЭЛ

Хянасан:
Аудитын менежер:

М.АЛТАНТУЯА

Дарга, Тэргүүлэх аудитор

Б.МӨНХБАТ

2/03

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар-ийн
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Н.ЭНХ-АМГАЛАН

НЯГТЛАН БОДОГЧ, Д.МӨНХТУЯА





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 01/ - 40560241

Номгон

БНА-2026/078/НА-СТА тмз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь цалингийн зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас өөртөө шийдвэр гарган нийт 1,855,000 төгрөгийг дараах байдлаар зарцуулжээ.

1. 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар 400,000 төгрөгийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан;

2. 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01, 2025 оны 10 дугаар 03-ны өдрийн Б/13, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/21 дүгээр тушаалаар хоол унааны нэмэгдэл олгох шийдвэр гарган нийт 1,455,000 төгрөгийн хоолны хөнгөлөлт эдэлсэн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан

6426090002

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын дарга нь өөртөө шийдвэр гаргадаг байдлыг таслан зогсоож, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 02-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Энх-Амгалан, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН?

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно